

МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ СОНИНЫ ХӨГЖЛИЙГ ҮЕЧЛЭХ АСУУДАЛД

Х.Ундрахбулаг*

*БНХАУ-ын ӨМӨЗО-ны Багшийн их сургуулийн Сонин мэдээний дээд сургуулийн багш, доктор (Ph.D)

Түлхүүр үгс: Монгол хэлт сонин хэвлэл, түүхэн хөгжил, үечлэл, сэтгүүл зүй судлаач.

Монголын сэтгүүл зүйн түүх судлалд шийдвэл зохих зүйлийн нэг нь монгол хэлт сонины түүхэн хөгжлийн асуудлыг үечлэх, түүний онцлогийг тодруулах юм. Монгол туургатны хэмжээнд гарч байсан сонин хэвлэлийг нэгтгэн судалж, монгол хэлт сонин гэдэг талаас нь нарийвчлан судлах шаардлагатай бөгөөд бид энэ удаад Монгол улс, Өвөр Монголын хэмжээнд гарч байсан сонин хэвлэлийг хамруулан үечлэн судлах оролдлого хийлээ. Энэ нь тухайн үед гарч байсан сонин хэвлэлийн байдлыг харгалдуулан үзэж, нэгтгэн тодорхойлсон хэрэг юм. Цаашид, зөвхөн хоёр улсын хэмжээнд биш бусад Монгол туургатны цараагаар нэгтгэн үзэж, харьцуулан судлах шаардлагатай юм.

Түүхийг үечлэх үндэслэл, улс орны хөгжлийн хандлага: Түүхэн хөгжлийн үе шатыг судлахад дэлхий дахинаа нийтээр дагаж мөрддөг нэлээд олон үечлэлийн арга, үндэслэл, шалгуурууд байдаг. Үүнд голдуу болж өнгөрсөн чухал түүхэн үйл явдлаар тодорхой үе шат болгон авч үзэх болон ямар нэгэн он жил, цаг хугацаагаар зааглан өөр өөр

үечлэх зэрэг байнга ашигладаг аргууд байдаг. Үүнээс гадна бас адил бус салбарт ашиглах тус тусын онцлогтой өвөрмөц аргууд байдгийг судлаачид дурдсан байдаг.

БНХАУ-ын ЛиоНин мужийн Да-лиан Их Сургуулийн багш ЛиуЯн “Нийгмийн хөгжлийн адил бус түүхэн үе шатыг хуваахад баримжаа нь юу вэ гэвэл: үечлэлийн үндэслэл нь тодорхой ганц нэг зүйлийг дагнаж мөрдөх болон олон зүйлийн үндэслэлийг хамруулан уялдуулан дүгнэж нэгэн үечлэл гаргах гэх хоёр өөр байдал байдаг” (ЛиуЯнь., 2008) гэж дүгнэжээ. Түүхэн явц дахь бусад чухал хэрэг учир буюу чухал түүхэн хүн, газар орон зэрэг нь энэ үечлэлийн судалгааны тодорхой үндэслэл стандарт болгон харгалзаж үзэх болно.

Бид судалгаандаа Монгол улс, Өвөр Монгол, БНХАУ-ын түүхчид, сэтгүүл зүй судлаачдын үечлэлийг баримтлан өөрсдийн ангилал, үечлэл хийхдээ Монгол улс, олон улсын сонин хэвлэлийн түүхэн үечлэл, ӨМӨЗО-ны монгол хэлт сонины хөгжлийн түүх, БНХАУ-ын сонины түүхэн үечлэл, ийнхүү үечилсэн судалгааны бүтээлүүдэд тулгуурлав.

Улмаар Монгол улс, БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны

нийгмийн хөгжлийн түүхэн үе, шатыг харгалдуулан үзэж, сонин хэвлэлийн хөгжил, хандлага ямар байсныг баримжаалан үечлэлээ хийлээ. Мөн сэтгүүл зүйн түүх нь тухайн улс орны хөгжлийн түүх байдгийн хувьд бид тухайн улс орны түүхийн үечлэлийг харгалзан үзэх шаардлагатай болсон юм.

“БНМАУ-ын түүх” /1981/ бүтээлд тухайн нийгэм цаг үеийнхээ үзэл, онол, хандлагын үүднээс түүхээ 9 үе болгож ангилаад, 8, 9 дэх үеийг дараах байдлаар нарийвчлан авч үзсэн байна. Үүнд:

“... VIII үе-Монгол ардын хувьсгал гарах түүхэн урьдчилсан нөхцөлүүд. 1905 оны оросын, 1917 оны Октябрийн хувьсгалын нөлөө. Ардын нам үүсэн байгуулагдсан. 1921 оны хувьсгал ба БНМАУ байгуулагдсан. IX үе-Капитализмыг алгасан социализмд дэвшин орсон Монголын хөгжил. Энэ үе нь дотроо хэд хэдэн шатад хуваагдана.

Нэгдүгээр шат – Империализм, феодализмыг эсэргүүцсэн нийт ардчилсан өөрчлөлтийн үе. Хөгжлийн капиталист бус замыг хангасан. Ардын аж ахуйд социалист сектор буй болсон. (1921-1940).

Хоёрдугаар шат – Социализмын үндсийг байгуулан үйлдвэрлэх хүчийг цаашид хөгжүүлсэн нь. Хөдөө аж ахуйг социалист ёсоор өөрчлөн байгуулсан. Улс орны нийт эдийн засагт социалист үйлдвэрлэлийн харилцаа ялж, улс ардын аж ахуйд социализмын нэгдсэн систем буй болсон (1940-1960).

Гуравдугаар шат – Социалист нийгмийг ба социализмын материал, техникийн баазыг байгуулж дуусгах нь. Социалист нийгмийн харилцааг боловсронгуй болгох. Хөдөлмөрчдийн коммунист хүмүүжлийг хүчтэй болгосон нь (1960 оноос). ...” (Бүгд Найрамдах

Монгол Ард Улсын түүх, 1981) гэж үечилжээ.

Монгол Улсын түүхийн хөгжлийн явцыг социалист нийгмийн судлаачдаас өмнө түүхчид өөрөөр авч үзэж, бичиж байсан нь ном бүтээлд тодорхой байдаг. Тухайлбал, түүхч А.Амарын бүтээлд “... Монгол улс өдгөө дахин шинээр мандаж тусгаар тогтносноос инагш ... ойр дөхмөөр нэгтгэн хураангуйлж зохиосон үндэсний түүх шастиргүй бөгөөд тус улс нь ардын хэмжээт цаазат улс байгуулсан арван гурван жилийн ой ба бүгд найрамдах засгийг явуулж үндсэн хуулийг баталсан арван жилийн ойн их баяр нь энэ онд тохиолдсон учир энэхүү их баярыг тохиолдуулан Монгол улсын түүхийг зохион бичиж гаргахаар тогтож, надад даалгасан ...” (Амар.А, 1989) гээд хэрхэн “Монголын товч түүх”-ийг бичсэн оршилдоо онцгойлон дурдсан байна. Эндээс үзэхэд Хэмжээт цаазат ардын төр эхний гурван жил болсныг тухайн үеийн түүхчид хүлээн зөвшөөрч байсны нотолгоо мөн боловч хожмын түүхчид асуудалд намч, ангич байр сууринаас хандах болсноор түүхийг арай өөрөөр үечилж ирснийг дараа дараагийн түүхийн бүтээлүүд гэрчилдэг. Тиймээс бид түүхийн бүтээлийн үечлэлийг А.Амарын номд байх үзэл санаатай харьцуулан харуулав.

1 990 оны ардчилсан өөрчлөлтийн дараа Монгол Улсын түүхийг өөрөөр авч үзэх болжээ. “Монголын түүх” /1911-2017/ бүтээлд:

- Сэргэн Мандсан Богд Хаант Монгол улс, (1911-1919.11).
- Хэмжээт Цаазат Монгол улс, (1921 оны 7 дугаар сарын 10-наас 1924 он дуустал).
- Бүгд Найрамдах Монгол Ард улс: I үе, (1924-1959), II үе, (1959-1990)

— Ардчилсан Монгол улс, (1990 оноос эдүгээ хүртэл) (Батсайхан.О, Лонжид.З, Энхбат.Ч, Баатар.С, Амарсанаа.С, 2018) гэж ангилан авч үзжээ.

Дээрх үечлэлийн дагуу хэсэг тус бүрд тухайн нийгэм дэх хэвлэл мэдээллийн салбарын хөгжлийг тоймлон авч үзсэн байна. Бид судалгаандаа Монгол хэлт сонин хэвлэлийг үечлэхдээ Монгол улсын түүхийн дээрх үечлэлийг харгалзан үзлээ.

Тэгвэл БНХАУ-ын улс төр, эдийн засаг, соёл урлаг, сэтгүүл зүйн бүх салбаруудад нийтлэг авч үздэг эртний үе, ойр үе, орчин үе, одоо үе гэх дөрвөн том үндсэн үе шат байдаг. Тодруулбал:

- Эртний үе - 1840 он, Хятадын эртний түүх,
- Ойр үе - 1840 он - 1919 он, Хятадын ойр үеийн түүх, 1840 онд хар тамхины нэгдүгээр дайн эхэлснээс 1919 оны эцэс хүртэлх үе.
- Орчин үе - 1919 он - 1949 он, Хятадын орчин үеийн түүх, 1919 оны 5-р сарын 4-ний хөдөлгөөнөөс эхэлж 1949 онд БНХАУ байгуулагдсанаар төгсдөг.
- Одоо үе - 1949 оноос - Хятадын одоо үеийн түүх. 1949 онд БНХАУ байгуулагдснаас өнөөг хүртэлх үе (杞乡青年个人图书馆. , 2019) ордог.

Хятадын нийгэм, түүхийн судлаачид үүнээс өөр баримжаа, түүхийн үечлэлийг хийдэггүй бөгөөд нам засгаас өгсөн чиглэлийн дагуу л ангилан үздэг байна. Тиймээс дээрх үечлэлийг харгалзан сонин хэвлэлийн хөгжлийг тодорхойлдог.

Хоёр улсын түүхийн үечлэлийг харахад нийгмийн хөгжлийн хандлага, баримжаа нь өөр өөр, туулсан цаг үе нь ч өөр байгаа хэдий ч зарим талаараа нийтлэг нэг хэв шинжийг хадгалж

байсан нь түүхээс харагдаж байна. Иймд бид дараагийн хэсэгт Монгол улс, Өвөр Монголд сонин хэвлэл хөгжсөн түүхийг үечлэн үзэхдээ дээрх нийгмийн хөгжлийн үечлэлийг харгалзуулан ижил ба ялгаатай талыг нь тодруулан нэгдсэн нэг үечлэл гаргах үндэслэл болгож авав.

Монгол хэлт сонин хэвлэлийн түүхэн хөгжлийг үечлэх асуудалд: Монгол Улсын сонин хэвлэлийн хөгжлийн түүх нь Өвөр Монголд үүссэн түүхэн хэрэг явдлаас ялгаатай, өөрсдийн гэсэн онцлогтой, нөлөөлсөн нөлөө, гадаад, дотоод хүчин зүйл нь тусдаа хэдий боловч монгол хэлт сонин хэвлэл үүссэн зүй тогтол, нөхцөл, нийгмийн зорилго нь ижил төстэй байна. Тиймээс бид хоёр орны сонин хэвлэлийн хөгжлийн түүхийг үечлэхдээ монгол хэлт сонин хэвлэл үүссэн цаг үеийн нөлөө, гадаад орнуудын хүчин чармайлтыг монгол сэхээтэн, тэргүүний дэвшилт үзэлтэй хүмүүс хэрхэн бодит ажил болгосныг нь түүхэн баримтад тулгуурлан ижил талыг нь харгалзан үзэж, тусгай ангилал, үечлэл хийх оролдлого хийлээ.

Олон улсад сэтгүүл зүй үүссэн түүх нь тус тусдаа ангилагдан үечлэгддэг хэдий ч Монгол улсын судлаач, доктор М.Зулькафиль, Ч.Чойсамба нар “Сэтгүүл зүйн түүх” (Зулькафиль.М, Чойсамба.Ч., 2005) бүтээлдээ дэлхий дахины сэтгүүл зүйн хөгжлийг он цагийг баримтлан ангилж, улс орны сэтгүүл зүйн хөгжлийн түүхийг чухал үйл явдал, гол гол үе шатаар нь ялган бичсэн байна.

Тэгвэл БНХАУ-ын сэтгүүл зүйн эрдэмтэн ЖанЮнРүе, ЖанЛөнДөн, Өвөр Монголын судлаач Төгсцогт нар:

“... 1-р үе, Хөрөнгөтөн ангийн сонин үүсэл;

2-р үе, Үгээгүй ангийн сонин бий болсон;

3-р үе, Ганцаар эзэмших хөрөнгөт ёсон дахь хөрөнгөт ангийн сонин мэдээллийн үйлс;

4-р үе, Арван сарын хувьсгалын дараах сонин мэдээллийн үйлс;

5-р үе, Америк улсын ганцаар эзэмшилт сонин мэдээллийн үйлс;

6-р үе, Англи, Франц, Японы ганцаар эзэмших сонин мэдээллийн үйлс;

7-р үе, Арван сарын хувьсгалын дараах үгээгүй ангийн сонин мэдээллийн үйлсийн хөгжилт;

8-р үе, Дэлхийн хоёрдугаар дайнаас хойших Ази, Африк, Латин Америкийн үндэстний тусгаар тогтносон улсын сонин мэдээллийн хөгжилт...” (Жан, 2000) зэрэг найм хувааж, дэлхийн сэтгүүл зүйн түүхийг ангилан судалжээ. Ингэхдээ голчлон улс орнуудын түүхэн цаг үеийн өөрчлөлт хувиралт болон чухал түүхэн үйл явдлыг гол үечлэлийн үндэс болгосон нь харагдана.

“Түүхэн үечлэлийн чухал нэг баримжаа бол үе шат хоорондоо тодорхой ялгаа зөрөөтэй байх асуудал болно” (张晓群, 崔保国, 2009). Тиймээс судлаачдын бүтээлд олон үечлэн судлах арга ашигласны үндсэн зорилго нь энэ юм.

XX зуунд Өвөр Монгол төдийгүй Хятад улсын сонин хэвлэлийн хөгжлийн түүхэнд хамгийн чухал нөлөө үзүүлсэн Феодал, Хөрөнгөт, Нийгэм журамт зэрэг нийгмийн байгууллын шинж чанарыг үндэслэн сонин хэвлэлийн түүхийг доорх гурван ерөнхий үе шатад хуваах боломжтой байна. Үүнд:

А) Феодалын байгууллын үеийн сонин хэвлэл, 1900-1911 он;

Б) Хөрөнгөт байгууллын үеийн сонин хэвлэл, 1911-1949 он;

В) Нийгэм журамт байгууллын үеийн сонин хэвлэл, 1949 оноос хойш.

Ингэж үзэх нь Хятадын ойр үеийн түүхэнд, 1911 онд СүнЖүнШаны удирдсан Цагаагчин гахай жилийн хувьсгал ялалт байгуулж, хуучин феодал нийгмийн байгууллыг түлхэн унагаснаар Бүгд Найрамдах Дундад Иргэн улс байгуулагдаж, даруй хөрөнгөт дарангуйлах засагт байгуулал эхэлсэн, улмаар 1949 онд БНХАУ-ыг байгуулж, нийгэм журамд дэвшин орох болсон нь тус үечлэлийг хийх гол үндэслэл болно.

Мөн Монгол улс нь XX зууны эхэн үеэс мөн л нийгмийн байгуулал нь өөрчлөгдсөн юм. Дээрх өөрчлөлтийн дагуу тус улсын сонин хэвлэлийн түүхийг ерөнхийд нь хоёр хэсэгт хувааж үзэх бодит боломж байна. Энэ үе шат нь хуваагдсан он жил, цаг хугацааны хувьд,

а) Феодалын байгууллын үеийн сонин хэвлэл, 1900-1921 он.

б) Нийгэм журамт байгууллын үеийн сонин хэвлэл, 1921 оноос хойш - гэж авч үзэх боломжтой. Энэ нь бид нийгмийн хөгжлийн байдлыг харгалзан үзэж, нийгмийн байгууллын хувьд солигдсон байдлыг нь үндэслэл болгосон хэрэг. 1921 онд Монгол улсад Д.Сүхбаатар зэрэг удирдагчид ардын хувьсгалыг удирдаж, Хэмжээт Цаазат Монгол улсыг байгуулж, улмаар 1924 оноос Нийгэм журамт БНМАУ-ыг байгуулав. Ингэснээр 1921 он нь энэхүү үечлэлийн тодорхой зааг болжээ.

Хэдийгээр Монгол улс болон Өвөр Монголд сонин хэвлэл үүссэн түүхийг нийгмийн байгууллын баримжааны хувьд дээрх мэт ангилж болох хэдий ч бид улам нарийсгаж, нийгмийн хандлагыг нь илүү тодруулж, тухайн цагт хэвлэгдсэн сонин хэвлэл нь нийгмийн үзэл бодлыг тусгаж байсны баримжааг үндэслэн шинэ үечлэл

гаргахыг судалгааны ажлын гол чиглэл болгосон юм.

Монгол Улсын сонин хэвлэлийн үүсэл хөгжлийн түүхийг судлаачид 1913 онд “Шинэ толь хэмээх бичиг” анх гарснаас эхэлж үздэг. Энэ тухай доктор Т.Етекбай “... Монгол Улс тусгаар тогтносон нийслэл Хүрээнд монгол хэлээр хэвлэгдсэн “Шинэ толь хэмээх бичиг” бол анхны сэтгүүл, анхны ном, бас анхны сонин байжээ...” (Етекбай.Т, 2019) гэж тэмдэглэжээ. Судлаачдын ангиллыг үзэхэд монгол хэлт сонин хэвлэл гарсан түүхийг өөрсдийн улс орны сэтгүүл зүйн хөгжлийн түүхэнд хамруулан үечилсэн нь байдаггүй. Анх Монголын сэтгүүл зүйн түүхч, эрдэмтэн Г.Дэлэг “... Манай судалж байгаа монголын тогтмол хэвлэл үүсэж хөгжсөн түүхийг дөрвөн хэсэгт хувааж болох юм. Тухайлбал,

1.Монгол хэл дээр гарсан анхны сонин сэтгүүл (1908-1919);

2.Монголын дэвшилт ардчилсан хэвлэл үүсэж бий болсон үе (1913-1920);

3.Монголын хувьсгалт хэвлэл үүсэн үе (1919-1921);

4.Ардын засгийн анхны жилүүдийн тогтмол хэвлэл (1921-1925) гэж үзэж болно...” (Дэлэг.Г, 1965) гэж “Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл” /1965/ номдоо дурдсан байна. Энэ нь монгол хэлт сонин хэвлэлийн түүхийг өөрсдийн улсын сэтгүүл зүйн түүхэнд хамруулан ангилсан анхны оролдлого байв. Гэвч хожмын судлаачид, мөн Г.Дэлэг гадаад орнуудаас монголчуудад зориулан гаргаж байсан сонин хэвлэлийг “Монгол хэвлэл” гэж нэрлэж, монголын сонин хэвлэлийн түүхээс тусгайлан ангилж үзэх болсон байна. Тухайлбал, профессор Л.Норовсүрэн монголын сэтгүүл зүйн түүхийг Бэлтгэл үе, Үндсэн үе гэж ерөнхийлөн хоёр

хувааж, үндсэн үеэ дараах байдлаар авч үзжээ. Үүнд:

“...Нэгдүгээр үе: Монголын үндэсний дэвшилт ардчилсан тогтмол хэвлэлийн үе (1913-1920 он);

Хоёрдугаар үе: Монголын хувьсгалт нууц хэвлэлийн үе (1919-1921 он);

Гуравдугаар үе: Монгол улсад социалист нийгэм байгуулахын төлөө тэмцлийн үеийн сэтгүүл зүй (1921-1990 он);

Дөрөвдүгээр үе: Монголын чөлөөт ардчилсан сэтгүүл зүйн үе (1990 оноос хойш)...” (Норовсүрэн.Л, 2000) гэж ангилжээ. Энд мөн л монгол хэлт сонин хэвлэл үүссэн 1895 оноос хойш гарсан тогтмол хэвлэлийг монголын сэтгүүл зүйд шууд хамаатай гэж үзэлгүй “Гадаад орнуудаас монголчуудад зориулан гаргаж байсан тогтмол хэвлэл” гэж нэрлэж, Бэлтгэл үед хамруулан үндэсний сэтгүүл зүйг бий болгоход тодорхой нөлөө үзүүлсэн гэж дэлгэрэнгүй судлан тодорхойлсон байна.

Харин Өвөр Монголын судлаач Бөх-Үндэс “Дундад улсын сонин мэдээний түүхэн тойм” номдоо БНХАУ-ын сонины түүхэн хөгжлийг арван үе шатад үечлэн судалжээ:

- ✓ Эртний үеийн сонин мэдээ;
- ✓ Ойр үеийн сонин мэдээлэл уламжлагдан орж ирсэн;
- ✓ Үндэстний ойр үеийн сонин мэдээлэл бий болсон;
- ✓ Цагаагчин гахай жилийн хувьсгалын үеийн сонин мэдээний үйлс;
- ✓ Иргэн улсын эхний үеийн сонин мэдээ;
- ✓ “Таван сарын дөрөвний” үе;
- ✓ Дундад улсын эв хамт нам байгуулагдах үе болон их хувьсгалын үе;
- ✓ Арван жилийн дотоодын дайны үе;
- ✓ Японыг эсэргүүцэх дайны үе;

✓ Чөлөөлөх дайны үе (Бөх-Үндэс, 2007)

зэрэг арван үед хувааж, сэтгүүл зүйн хөгжлийн түүхэн байдлыг судлан үзжээ. Энэ нь мөн л өөрсдийн улс орны сэтгүүл зүйн хөгжлийг түүхэн хэрэг явдалтай шууд уялдуулан ангилсан улс төрийн агуулгатай үечлэл болсон байна.

Мөн Өвөр Монголын судлаач Дархан тус орны монгол хэлт сонин үүсэл хөгжлийг: "...Монгол сонин сэтгүүлийн үүсэл, ХХ зууны эхний хагас дахь сонин сэтгүүл ба ХХ зууны сүүлчийн хагас дахь сонин сэтгүүл..." (Дархан.Б, 2010) гэж гурван үндсэн үе шатад хуваажээ. Үүнд, ХХ зууны эхний хагас зууны үеийг судлахдаа Дундад иргэн улс байгуулагдахаас өмнөх үе, Дундад иргэн улс байгуулагдсаны дараа арав хориод оны үе ба ХХ зууны 30, 40-өөд оны үе зэрэг хэдэн шат болгон ангилж үзжээ. Харин ХХ зууны сүүлчийн хагас үеийг судлахдаа дотор нь нарийвчилсан түүхэн үе шат хуваасангүй, улсын, мужийн, аймаг, хотын, хошууны, их дээд сургуулиудын сонинууд гэж дэс давхарга хуваан төрөлжүүлэн үзжээ.

Өвөр Монголын судлаачид нийгмийн хөгжлийн үе шатыг харгалзуулан авч үзэхээс илүүтэйгээр он цагийн баримжаанд тулгуурлан үечилсэн болох нь харагдана. Ингэснээр сонин хэвлэлийн хөгжлийн онцлог, мөн чанарыг тодорхойлох боломж хомс болж байна.

Дээрх судлаачдын үечлэл, ангиллаас харахад Монгол улс, Өвөр Монголын сонин хэвлэлийн түүхэн хөгжлийг яг ижил нэг цаг хугацааны тодорхой ангилалд шууд оруулж нэгтгэн үечлэх боломжгүй гэдэг нь тодорхой байна. Учир нь энэ хоёр улс өөр өөр нийгмийн байгууллыг туулж, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал, бодлого зохицуулалт нь тусдаа байсан учир шууд хамаатуулан авч үзэх бодит боломж хомс байгаа нь харагдаж байна. Тийм ч учраас сонин хэвлэлийн хөгжлийн түүх нь ч нийгмийн хандлагаас шалтгаалан өөр өөр замыг туулжээ. Гэвч бид нийгмийн хөгжлийн өөр өөр байдлыг харгалзаж, монгол хэлт сонин хэвлэл үүссэн нөхцөл байдлыг харьцуулан үзэхийн тулд ижил төстэй мөн чанар, нөхцөл байдлыг нь харгалзан шинээр үечлэн үзэх оролдлого

хийв. Улс орны хөгжлийн түүхийн үечлэл, нэршил нь өөр, сонин хэвлэлийн туулсан замнал нь бага зэрэг ялгаатай байгаа хэдий ч бидэнд зарим ижил, төстэй шинж чанарт нь тулгуурлан судлаачдын тус тусдаа хийсэн үечлэлийг нэгтгэн хийлээ.

Иймээс Монгол улсын нийгмийн хөгжлийн хандлагыг дагаж, сонин хэвлэлийн хөгжлийн түүхийг:

- Үүсэл үе;
- Хувьсгалын ардчилсан шатны зорилтот тэмцлийн үе;
- Нийгэм журам буюу социализмын үндсийг тавьж, коммунист хэвлэл хөгжсөн үе;

«

Өвөр Монголын судлаачид нийгмийн хөгжлийн үе шатыг харгалзуулан авч үзэхээс илүүтэйгээр он цагийн баримжаанд тулгуурлан үечилсэн болох нь харагдана. Ингэснээр сонин хэвлэлийн хөгжлийн онцлог, мөн чанарыг тодорхойлох боломж хомс болж байна

»

- Чөлөөт хэвлэлийн үе гэж үзэж болохоор байна.

Тэгвэл Өвөр Монголын сонин хэвлэлийн хөгжлийг үечлэхдээ туулж өнгөрүүлсэн нийгмийн байгуулал, амьдралын хэв шинжийг давхар харгалзан үзэж:

- Үүсэл үе;
- Нийгэм журамт улс байгуулахын төлөө тэмцлийн үе;
- Шинэ нийгэм журамт нийгмийн замналын үе;
- Өөрчлөлт шинэчлэлийн үе гэж үзэх боломжтой байна.

Дүгнэлт: Бид энэхүү байдлыг харгалзан үзэж, тэдгээрийн хамгийн ерөнхий, адил төсөөт, түүхэн үйл явдлууд дээр тулгуурлаад ерөнхийлсөн нэг ангилал хийж үзэж байгаа юм. Энэ нь хоёр улс орны нийгэм, улс төрийн түүхэн хөгжил, үйл явдлыг яг нэг доор адилтгаж, яг ижил үе шатуудыг туулсан хэмээн нэгтгэн үзэж, хатуу нэг үечлэлд шахаж багтааж байгаа хэрэг биш, зөвхөн энэхүү хөрш зэргэлдээ хоёр орон, ердөө адилхан монгол хэлээр сонин гарсан, ойролцоо цаг хугацааны доторх үйл явдал зэрэг адил төсөөтэй олон зүйлийг харгалзан, монгол хэлээр гарсан сонины үүсэл, хөгжлийн түүхийг хоёр орны хэмжээнд харьцуулсан нэгэн ерөнхий ангилал хийж байна. Ингэснээр хоёр улсын монгол хэлт сонины үүсэл хөгжлийг ерөнхийлөн судлах, харьцуулсан судалгаа хийхэд харгалзан үзэх, үе шаттай цэгцтэй нэгдсэн ойлголтыг өгөх зорилготой юм.

Мөн судлаачид зөвхөн тус тусынхаа улсын сонин хэвлэлийн түүхийг үечилсэн, харин монгол хэлт сонин хэвлэлийн түүхийг ерөнхийлөн үечлэн үзсэн нь үгүй байна. Бид хоёр орны сэтгүүл зүйн эрдэмтдийн түүхэн үечлэлийн судалгаануудыг харгалзан үзсэн ба үечлэн судлах арга, зарчимд

тулгуурлан, Монгол ба Өвөр Монголын сонин хэвлэлийн түүхэн хөгжлийн явц онцлогт үндэслэн хоёр орны түүхэн байдлыг харьцуулж монгол хэлт сонин хэвлэлийг дараах байдлаар үечлэн үзэж байна. Үүнд:

- **Нэгдүгээр үе:** Монгол хэлт тогтмол хэвлэлийн үүсэл үе, /1895-1920/;
- **Хоёрдугаар үе:** Нийгэм журам байгуулах тэмцлийн үеийн монгол хэлт тогтмол хэвлэл, /1921-1950 аад/;
- **Гуравдугаар үе:** Коммунист сэтгүүл зүйн үеийн монгол хэлт тогтмол хэвлэл, /1950 аад-1990/;
- **Дөрөвдүгээр үе:** Нэн шинэ үеийн монгол хэлт тогтмол хэвлэл, /1991 оноос одоог хүртэл/ гэж үзэх нь нийгмийн хөгжлийн байдал, сонин хэвлэлийн хөгжлийн үе шатыг бүрэн тусгах боломжтой гэж үзлээ.

Эшлэл

1. Янь. Лю (2008). “Мао Зэдуны сэтгэлгээний судалгаа э/ш-ний өгүүлэл// “CNKI”-ийн эрдэм шинжилгээний бичиг. Бээжин., /刘岩.“毛泽东思想研究”.中国知网学术论文 . х.158.
2. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх. (1981). УБ., х.18.
3. Амар А. (1989). Монголын товч түүх. УБ., х.17
4. Батсайхан О., Лонжид З., Энхбат Ч., Баатар С., Амарсанаа С. (2018). Монголын түүх /1911-2017/. УБ. х.11.
5. 杞乡青年个人图书馆.(2019.12.25).古代近代现代当代.
http://www.360doc.com/content/19/12/25/22/3595160_882206147.shtml
6. Зулькафиль М., Чойсамба Ч. (2005). Сэтгүүл зүйн түүх. УБ. х.3-4.
7. Юн Рүе Жан. (2000). Гадаадын сэтгүүл зүйн үйлсийн түүх. Ү-Хан хот. х. 41./张允若 外国新闻事业史.

8. 崔保国. 张晓群.
“中国报纸产业发展的回顾与展望”学术论
文. /DOI:10.13854/j.cnki.cni. 2009.03.05/.
9. Етекбай Т. (2019). Монгол улсын орчин
үеийн ном хэвлэлийн үүсэл хөгжлийн
асуудал /1911-1940/. УБ., х.58.
10. Дэлэг Г. (1965). Монголын Сэтгүүлчдийн
Холбоо, Монгол тогтмол хэвлэлийн
түүхэн тэмдэглэл., УБ., х.402.
11. Норовсүрэн Л. (2000). Монголын сэтгүүл
зүйн түүхэн тойм. Тэргүүн дэвтэр. УБ.,
х.10.
12. Бөх-Үндэс. (2007). Дундад улсын сонин
мэдээний түүхэн тойм. Хөх хот. х.35.
13. Дархан Б. (2010). Монгол сонин
мэдээлэл зүйн түүхэн хөтөлбөр. Хөх
Хот. х.5.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Амар А. (1989). Монголын товч түүх. УБ.
2. Батсайхан О., Лонжид З., Энхбат Ч.,
Баатар С., Амарсанаа С. (2018).
Монголын түүх /1911-2017/. УБ.
3. (1981). Бүгд Найрамдах Монгол Ард
Улсын түүх. УБ.
4. Бөх-Үндэс. (2007). Дундад улсын сонин
мэдээний түүхэн тойм. Хөх хот.
5. Дархан Б. (2010). Монгол сонин
мэдээлэл зүйн түүхэн хөтөлбөр. Хөх
Хот.
6. Дэлэг Г. (1965). Монголын Сэтгүүлчдийн
Холбоо, Монгол тогтмол хэвлэлийн
түүхэн тэмдэглэл., УБ.
7. 杞乡青年个人图书馆.(2019.12.25).古代近
代现代当代.http://www.360doc.com/content/19/1225/22/3595160_882206147.shtml
8. Етекбай Т. (2019). Монгол улсын орчин
үеийн ном хэвлэлийн үүсэл хөгжлийн
асуудал /1911-1940/. УБ.
9. Зулькафиль М., Чойсамба Ч. (2005).
Сэтгүүл зүйн түүх. УБ.
10. Норовсүрэн Л. (2000). Монголын сэтгүүл
зүйн түүхэн тойм. Тэргүүн дэвтэр. УБ.,
х.10.
11. Юн Рүе Жан. (2000). Гадаадын сэтгүүл
зүйн үйлсийн түүх. Ү-Хан хот.

12. 崔保国. 张晓群.
“中国报纸产业发展的回顾与展望”学术论
文. /DOI:10.13854/j.cnki.cni. 2009.03.05/.
13. Янь. Лю (2008). “Мао Зэдуны
сэтгэлгээний судалгаа э/ш-ний өгүүлэл//
“CNKI”-ийн эрдэм шинжилгээний бичиг.
Бээжин./刘岩.“毛泽东思想研究”.中国知网
学术论文.

Summary

With the acceptance of centrally resided Mongolians in Inner Mongolia of China and The Republic of Buryatia, Tuva and Kalmyk in Russia since XX century, they have communicated in their native language in social communication, and more specifically, the common mass communication systems have already been created for the reception of information in their native language. From the historical perspectives of mass media, it has created an overview of the origins and development of ‘The Mongolian-language newspapers and press’ which can be considered as ‘national’ for Mongolians abroad.

With respect to some research proposals on the periods of historical development of journalism designed by scholars of two countries, the periods of origins and development of The Mongolian-language newspapers can be divided in what follows:

- a. First period: Period of origin of The Mongolian-language press, /1895-1920/;
- b. Second period: Period of Conflicts to set up social organizations, /1921-1950s/;
- c. Third period: Period of Communist Press Development, /1950s-1990/;
- d. Fourth period: Period of Shake-up Press, /1990 – present/.

In revising the periods of historical development of The Mongolian-language newspapers published in Mongolia and Inner Mongolia, the study aims at comparing the special features of The Mongolian-language newspapers in each period.